



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 28
танай _____-ны № _____-т

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА С.ЧУЛУУНБАТ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10 441 214,16	11 142 353,16
33	АВЛАГА	3 612 305,16	265 304,16
335	Бусад авлага	3 612 305,16	265 304,16
3351	Байгууллагаас авах авлага	3 612 305,16	265 304,16
35	БАРАА МАТЕРИАЛ	6 828 909,00	10 877 049,00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	264 000,00	00,00
35110	Тусгай зориулалттай материал		790 000,00
354	Хангамжийн материал	6 564 909,00	10 087 049,00
35410	Бичиг хэргийн материал	1 825 759,00	6 599 159,00
35420	Аж ахуйн материал	4 739 150,00	3 487 890,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	83 933 158,16	106 352 305,44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	83 933 158,16	106 352 305,44
392	Биет хөрөнгө	83 658 158,16	105 732 305,40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20 000 000,00	20 000 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16 385 668,22	-20 000 000,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	209 698 678,35	238 774 950,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-142 259 403,09	-152 530 408,52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33 168 347,31	26 386 280,20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20 563 796,19	-6 898 516,28
393	Биет бус хөрөнгө	275 000,00	620 000,04
39301	Программ хангамж	997 500,00	797 500,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-722 500,00	-577 499,96
39303	Бусад биет бус хөрөнгө		400 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	94 374 372,32	117 494 658,60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	94 374 372,32	117 494 658,60
51	Засгийн газрын хувь оролцоо	94 374 372,32	117 494 658,60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41 179 695,00	41 179 695,00
51101	Өмч: - төрийн	41 179 695,00	41 179 695,00
512	Хуримтлагдсан үр дүн	51 459 737,79	75 314 963,60
51210	Өмнөх үеийн үр дүн	51 459 737,79	52 194 677,32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 734 939,53	1 000 000,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	94 374 372,32	117 494 658,60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	361 817 003,20	376 039 040,26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118 830 403,20	108 672 140,26
120	Нийтлэг татварын бус орлого	118 830 403,20	108 672 140,26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	114 396 530,00	102 803 390,26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114 396 530,00	102 323 390,26

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242 986 600,00	267 366 900,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239 326 600,00	267 366 900,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239 326 600,00	267 366 900,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	342 228 664,24	351 300 553,98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342 228 664,24	351 300 553,98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284 760 235,79	263 143 612,88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160 388 098,18	150 504 791,65
210101	Үндсэн цалин	129 205 225,94	93 050 435,93
210102	Нэмэгдэл	19 142 831,24	51 438 605,72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5 229 100,00	6 015 750,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 540 905,88	19 851 655,48
210201	Тэтгэврийн даатгал	14 877 502,55	13 658 803,40
210202	Тэтгэмжийн даатгал	1 599 330,04	1 735 764,49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 265 836,60	1 203 719,03
210204	Ажилгүйдлийн даатгал	238 562,62	295 760,89
210205	Эрүүл мэндийн даатгал	3 559 674,07	2 957 607,67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27 422 461,14	27 566 625,33
210301	Гэрэл, цахилгаан	611 432,00	629 209,38
210302	Түлш, халаалт	3 769 770,08	3 837 755,09
210303	Цэвэр, бохир ус	876 779,06	935 180,86
210304	Байрны түрээс	22 164 480,00	22 164 480,00
2104	Хангамж, бараа материалын зардал	11 663 192,00	10 111 678,70
210401	Бичиг хэрэг	2 914 665,00	2 387 210,00
210402	Тээвэр, шатахуун	4 856 790,00	4 568 400,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 237 555,00	1 766 277,70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 340 589,00	1 389 791,00
2105	Нормативт зардал	3 794 950,00	1 439 400,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2 795 000,00	1 439 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5 200 000,00	4 033 280,00
210601	Багаж хэрэгсэл		83 780,00
210604	Урсгал засвар	4 400 000,00	3 949 500,00
2107	Томилолт, зочны зардал	7 654 000,00	5 545 000,00
210702	Дотоод албан томилолт	7 654 000,00	5 545 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 951 780,00	1 524 900,00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		264 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	676 780,00	471 900,00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22 000,00	22 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	710 900,00	767 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45 144 848,59	42 566 281,72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5 924 554,00	2 234 409,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 136 982,00	776 900,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37 083 312,59	39 554 972,72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57 468 428,45	88 156 941,10
2132	Бусад урсгал шилжүүлэг	53 105 100,00	50 230 006,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52 355 100,00	49 630 006,00

**Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750 000,00	600 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4 363 328,45	37 926 935,10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4 363 328,45	37 926 935,10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	19 588 338,96	24 738 486,28
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		1 621 000,00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		3 239 200,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	19 588 338,96	23 120 286,28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.0	1,734,939.53	(31,871,398.83)	74,786,033.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,179,695.0	1,734,939.53	(31,871,398.83)	74,786,033.36
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			82,870,815.01	82,870,815.01
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.0	1,734,939.53	51,459,737.79	94,374,372.32
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,179,695.0	1,734,939.53	51,459,737.79	94,374,372.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			734,939.53	734,939.53
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,179,695.0	1,734,939.53	52,194,677.32	95,109,311.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(734,939.53)		(734,939.53)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			23,120,286.28	23,120,286.28
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,179,695.0	1,000,000.0	75,314,963.60	117,144,658.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	362 904 930,00	370 170 290,26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118 967 530,00	102 803 390,26
120	Нийтлэг татварын бус орлого	118 967 530,00	102 803 390,26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118 967 530,00	102 803 390,26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118 967 530,00	102 323 390,26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	480 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	243 937 400,00	267 366 900,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239 326 600,00	267 366 900,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239 326 600,00	267 366 900,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	308 466 130,00	309 817 170,26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	308 466 130,00	309 817 170,26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250 997 701,55	221 660 229,16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160 388 099,18	150 504 791,65
210101	Үндсэн цалин	107 692 444,94	98 825 565,16
210102	Нэмэгдэл	47 466 554,24	46 347 476,49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5 229 100,00	5 331 750,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 633 114,23	19 851 655,48
210201	Тэтгэврийн даатгал	15 236 899,08	14 728 095,22
210202	Тэтгэмжийн даатгал	1 603 899,04	1 291 296,40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 283 099,42	1 007 933,70
210204	Ажилгүйдлийн даатгал	337 089,62	249 339,21
210205	Эрүүл мэндийн даатгал	3 172 127,07	2 574 990,95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30 245 443,14	24 219 624,33
210301	Гэрэл, цахилгаан	880 756,00	66 209,38
210302	Түлш, халаалт	4 718 771,08	2 977 474,95
210303	Цэвэр, бохир ус	646 436,06	846 460,00
210304	Байрны түрээс	23 999 480,00	20 329 480,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9 473 815,00	9 474 677,70
210401	Бичиг хэрэг	1 999 960,00	1 860 000,00
210402	Тээвэр, шатахуун	4 672 800,00	4 568 400,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 237 555,00	1 766 277,70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 500 000,00	1 280 000,00
2105	Нормативт зардал	3 794 950,00	1 439 400,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2 795 000,00	1 439 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5 970 000,00	6 343 280,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	170 000,00	1 703 780,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800 000,00	640 000,00
210604	Урсгал засвар	5 000 000,00	3 999 500,00
2107	Томилолт, зочны зардал	7 654 000,00	5 545 000,00
210702	Дотоод албан томилолт	7 654 000,00	5 545 000,00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2 438 780,00	1 524 900,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00,00	264 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	676 780,00	471 900,00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22 000,00	22 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 197 900,00	767 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9 399 500,00	2 756 900,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6 399 500,00	1 980 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 000 000,00	776 900,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57 468 428,45	88 156 941,10
2132	Бусад урсгал шилжүүлэг	53 105 100,00	50 230 006,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52 355 100,00	49 630 006,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750 000,00	600 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4 363 328,45	37 926 935,10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4 363 328,45	37 926 935,10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	54 438 800,00	60 353 120,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54 438 800,00	60 353 120,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54 438 800,00	60 353 120,00
2200	Дотоод эх үүсвэрээр	54 438 800,00	60 353 120,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54 438 800,00	60 353 120,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-54 438 800,00	-60 353 120,00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	347 366 900,00	331 773 455,16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347 366 900,00	331 773 455,16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296 288 300,00	281 543 449,16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157 751 600,00	150 504 791,65
210101	Үндсэн цалин	110 148 700,00	98 825 565,16
210102	Нэмэгдэл	43 263 400,00	46 347 476,49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4 339 500,00	5 331 750,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 296 400,00	19 851 655,48
210201	Тэтгэврийн даатгал	14 986 400,00	14 728 095,22
210202	Тэтгэмжийн даатгал	1 577 500,00	1 291 296,40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 262 000,00	1 007 933,70
210204	Ажилгүйдлийн даатгал	315 500,00	249 339,21
210205	Эрүүл мэндийн даатгал	3 155 000,00	2 574 990,95

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29 800 700,00	24 219 624,33
210301	Гэрэл, цахилгаан	764 000,00	66 209,38
210302	Түлш, халаалт	4 271 200,00	2 977 474,95
210303	Цэвэр, бохир ус	765 500,00	846 460,00
210304	Байрны түрээс	24 000 000,00	20 329 480,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9 582 400,00	9 474 677,70
210401	Бичиг хэрэг	1 860 000,00	1 860 000,00
210402	Тээвэр, шатахуун	4 568 400,00	4 568 400,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 820 000,00	1 766 277,70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54 000,00	00,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 280 000,00	1 280 000,00
2105	Нормативт зардал	1 440 000,00	1 439 400,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 440 000,00	1 439 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65 827 000,00	65 826 500,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	61 187 000,00	61 187 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	640 000,00	640 000,00
210604	Урсгал засвар	4 000 000,00	3 999 500,00
2107	Томилолт, зочны зардал	5 546 000,00	5 545 000,00
210702	Дотоод албан томилолт	5 546 000,00	5 545 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2 287 200,00	1 924 900,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	264 000,00	264 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	682 000,00	471 900,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106 500,00	00,00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24 200,00	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400 000,00	400 000,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	43 400,00	00,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	767 100,00	767 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2 757 000,00	2 756 900,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1 980 000,00	1 980 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	777 000,00	776 900,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51078600,00	50230006,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51 078 600,00	50 230 006,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50 478 600,00	49 630 006,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600 000,00	600 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	347 366 900,00	331 773 455,16
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	216 288 300,00	229 450 064,90
131001	Улсын төсвөөс санхүүжих	216 288 300,00	229 450 064,90
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	131 078 600,00	102 323 390,26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131 078 600,00	102 323 390,26
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01,00	01,00
610001	Төсвийн байгууллага	01,00	01,00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13,00	13,00

620001	Удирдах ажилтан	01,00	01,00
620002	Гүйцэтгэх ажилтан	09,00	09,00
620003	Үйлчлэх ажилтан	03,00	03,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	480 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	480 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469 900,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	469 900,00
210602	Тавилга	469 900,00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10 100,00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	10 100,00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт хэмжил зүйн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Стандарт хэмжил зүйн газар нь Орхон аймагт стандартчилал хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант онд Дээд шатны төсвийн захирагчаас Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын дагуу хэмнэлтийн горимд ажиллах, тэвчиж болох зардлыг тэвчих чиглэл өгсөн энэ чиглэлээр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт хэмжил зүйн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 267 336.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2 673.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1 871.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,120.3 мянган төгрөгөөр буюу 0.25 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Авлага	3,612.3	265.3	(3,347.0)
Бараа материал	6,828.9	10,877.0	4,048.1
Үндсэн хөрөнгө	83,933.2	106,352.3	22,419.1
Нийт хөрөнгө	94,374.4	117,494.7	23,120.3
Өр төлбөр	0.0	0.0	

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	94,374.4	117,494.7	23,120.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	94,374.4	117,494.7	23,120.3

Бараа материалын дансний үлдэгдэл өмнөх оныхоос 10,877.0 мянган төгрөг болж 4,048.1 мянган төгрөгөөр өссөн нь 5,868.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 106,352.3 мянган төгрөг болж 22,419.1 мянган төгрөгөөр өссөн нь 51,814.9 мянган төгрөгийн эталон хэмжих тоног төхөөрөмж, 8,138.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмж авснаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 117,494.7 мянган төгрөг болж 23,120.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Стандарт хэмжил зүйн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 14,222.0 мянган төгрөгөөр буюу 3,8 хувиар, нийт зардал өмнөх оноос 9,071.9 мянган төгрөгөөр буюу 2,6 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Стандарт хэмжил зүйн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 267,366.0 мянган төгрөгөөр, тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, 267,366.0 мянган төгрөгөөр төсвийг батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 267,366.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 102,803.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 480.0 мянган төгрөгийг орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 309,817.2 мянган төгрөгийг зарцуулж, 37,926.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 331,773.4 мянган төгрөг буюу 89.7 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 7,246.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,444.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,581.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 107.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 364,4 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын 848,6 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгууллагаас төлбөртэй сургалт явуулсны үр дүнд 480.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна. Үүнээс 469.9 мянган төгрөгийг сургалтын танхимдаа ширээ авахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй хэдий ч санхүүгийн тайланд биет бус хөрөнгийг бүртгээгүй санхүүгийн УСНББОУС болон НБББББ-т заасантай нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Стандарт хэмжил зүйн газар нь 2021 онд нийт 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 142 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж 4-р сард 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 6,493.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,347.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	2	6,493.8	2	6,493.8	0	0	
Зөвлөмж	2	3,347.0	2	3,347.0	0	0	
Нийт дүн	4	9,840.8	4	9,840.8	0	0	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар тогтмол зардал болон урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 840.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 400.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 175.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 265.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж, шилэн дансны хугацаа хоцроосон мэдээнүүдэд 1 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Харилцах болон ерөнхий журналас гүйлгээг хянахад 400.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй байсныг холбогдох дансанд залруулж тайлагнуулав.

4.3 Албан шаардлага

Тайлант онд ажиллаж байсан үйлчлэгчийн цалинг бодохдоо 5 сараас хойш нийгмийн даатгалын кодчиллыг буруу тооцон 175.6 мянган төгрөгийг илүү суутгасан тул 1 албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 265.3 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагатай байсан ба Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу “төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтын дагуу удаан хугацаанд төлөгдөхгүй байгаа авлагыг найдваргүй болохыг тогтоон шийдвэрлүүлэх.

Өгсөн зөвлөмж:

Найдваргүй болсон авлагыг шийдвэрлүүлж, найдваргүй авлагын зардалд бүртгэх.

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд мэдээлэх 146 талбарын мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “шилэн дансны мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх”;

4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Стандарт хэмжил зүйн газар	4	840.9	1	400.0			1	175.6	2	265.3
Нийт		4	840.9	1	400.0			1	175.6	2	265.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

